



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/389

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн (Булган хотноо) зохион байгуулагдах “Алтаргана” олон улсын наадамд Хөвсгөл аймгаас оролцох баг бүрэлдэхүүний тоглолт, үйл ажиллагааны зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг зарцуулсугай.

2. “Алтаргана” олон улсын наадамд оролцох зардал 3,000,000 төгрөгийг “Эрх зүй, нийгмийн хэв журам хангах” хөтөлбөрийн “Засаг даргад хуулиар олгосон эрх хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөрөнгийг зохих журмын дагуу төлөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулж, тайлагнахыг Соёл, урлагийн газрын дарга (Л.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

